



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/88

Шивээговь сум

Коронавируст халдвар (Ковид-19)-ын  
эрсдэлээс урьдчилан сэргийлэх  
хариу арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6,а, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 154 дүгээр “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/162 дугаар захирамж, сумын Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 30 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улсын хэмжээнд 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан хязгаарлалт тогтоох төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор нийслэл Улаанбаатар хот болон халдварын голомтын бүс нутгаас ирж байгаа иргэдийн орох, гарах хөдөлгөөнийг Улсын Онцгой комиссын даргын 46 дугаар тушаалаар баталсан “Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-аар зохицуулсугай.

3. Төрийн болон хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийг Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг QR кодоор бүртгэлжүүлэх, халдвар хамгааллын дэглэм, холбогдох хууль тогтоомж, дүрэм

42121°470

журмыг мөрдөж ажиллахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг 08:00-21:00 цагийн хооронд байхаар тогтоож, хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Эрдэнэтулга), Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр) нарт үүрэг болгосугай.

5. Сумын хэмжээнд иргэдийг дархлаажуулах ажлыг эрчимжүүлэх, 12-17 насны хүүхдүүдийг дархлаажуулалтад хамруулах бэлтгэл ажлыг хангах, вакцины тээвэрлэлт, хадгалалтын горимд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Сувданцэцэг), Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр) нарт үүрэг болгосугай.


6. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн зохион байгуулахыг Ерөнхий боловсролын сургуулийг захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Энхриймаа)-д үүрэг болгосугай.

7. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмжийг мэдээллийн бүх сувгаар хүргэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Онцгой комиссын гишүүн (Э.Төрмандах)-д үүрэг болгосугай.

8. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, үр дүнг тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч дарга (Ч.Сугармаа) нарт тус тус үүрэг болгосугай.

9. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/72 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2021 оны 06-р сарын 02-ны өдрийн 1188 дугаар захирамжийн хавсралт



Хязгаарлалт тогтоох төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн үйл ажиллагааны жагсаалт

№	Үйл ажиллагаа	Тавигдах шаардлага
1	Олныг хамарсан жагсаал цуглаан	Бүрэн хориглох
2	Бүх төрлийн баар, цэнгээний газар, караоке	
3	Цахим ба автомат тоглоомын газар болон бүх төрлийн тоглоомын төв	
4	Соёл, урлагийн арга хэмжээ, үзвэр үйлчилгээ	
5	Биеийн тамир, спортын тэмцээн уралдааны арга хэмжээ	
6	Аялал зугаалга	Гэр бүлийн хүрээнд
7	Сургалтын төв	10-аас дээш хүнтэй
8	Алжаал тайлах төв	Вакцины бүрэн тун авснаас хойш 14 түүнээс дээш хносон, дархлаа тогтсон иргэдийг үйлчилгээний заалны 50 хүртэл хувьд хүлээн авах
9	Чийрэгжүүлэх, бялдаржуулах төв, спиннинг	
10	Саун, бассейн	
11	Амралт, жуулчны бааз	
12	Шашны зан үйл, сүм хийд, мөргөлийн газрууд	
13	Олимп, тив дэлхий олон улсын тэмцээний бэлтгэл	
14	Нийтийн бүжиг ба бүх төрлийн клуб	